



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

8-Р САР

Э-сонин

73-р дугаар





Зах зээлийн тойм

/2019.08.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

22

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

1,851,620,241

Хувьцаа /анхдагч/

0

Хувьцаа /хоёрдогч/

1,772,613,961

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

79,006,280

Компанийн бонд /анхдагч/

0

Компанийн бонд /хоёрдогч/

0

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

4,732,262

Хувьцаа /анхдагч/

0

Хувьцаа /хоёрдогч/

4,731,480

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

782

Компанийн бонд /анхдагч/

0


Компанийн бонд /хоёрдогч/

0


4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

4,240


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо

199

100% төрийн өмчит

18

Төрийн өмчийн оролцоотой

10

Хувийн өмчийн

171

I ангилал

14

II ангилал

44

III ангилал

140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо

57

Үүнээс: Брокер, Дилер

51

Андеррайтер

24

Хөрөнгө оруулалтын зөвлөх

13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.08.31ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард секюритиз ХХК	858,470	501,539,796	889,692	455,569,378	957,109,175
2	БиДиСек ХК	628,272	284,977,606	299,622	261,716,068	546,693,674
3	Стандарт инвестмент ХХК	800,527	143,524,232	699,921	143,721,484	287,245,716
4	Голомт Капитал ХХК	355,626	135,074,084	479,644	145,260,871	280,334,955
5	Бумбат-Алтай ХХК	303,324	153,102,760	236,434	118,863,723	271,966,483
6	Ти Ди Би Капитал ХХК	335,003	100,312,820	330,380	161,503,920	261,816,740
7	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	369,713	84,179,647	464,937	102,807,316	186,986,963
8	Гаули ХХК	242,921	85,839,723	286,679	67,013,815	152,853,538
9	Алекс Капитал ҮЦК	59,948	23,464,263	82,512	91,663,214	115,127,477
10	Инвекор капитал ҮЦК	47,077	88,116,116	665	1,290,100	89,406,216
11	Новел инвестмент ХХК	124,962	48,485,318	214,153	36,844,706	85,330,024
12	Централ секьюритиз ҮЦК	65,142	29,715,000	70,434	22,026,624	51,741,624
13	Эм Ай Би Жи ХХК	51,418	15,529,245	79,648	35,748,930	51,278,175
14	Лайфтайм инвестмент ХХК	4,825	30,094,870	2,569	12,792,350	42,887,220
15	Нэйшнл секюритис ХХК	0	0	118,891	41,722,196	41,722,196
16	Зэргэд ХХК	32,192	11,037,159	65,632	29,517,179	40,554,338
17	Таван богд ХХК	100	27,800	87,644	31,931,299	31,959,099
18	Монсек ХХК	29,834	23,642,006	5,626	3,515,760	27,157,766
19	Тулгат чандмань баян ХХК	13,268	14,773,875	19,051	11,580,935	26,354,810
20	Ард капитал групп ХХК	110,313	13,276,059	96,325	12,409,920	25,685,978

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.08.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	336,815	528,375,692	2,090	1,200	-32.29
2	GOV	ГОВЬ	804,172	239,658,408	334	276	-1.35
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	29,260	192,119,360	6,950	6,500	2.49
4	APU	АПУ	331,380	177,113,774	560	500	-9.05
5	INV	ИНВЕКОР ББСБ	57,466	107,340,546	1,940	1,750	5.49
6	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	240,803	84,607,162	359	306	-4.44
7	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	11,491	59,678,735	5,300	5,150	0.19
8	BDS	БИ ДИ СЕК	68251	57013894.1	950	831	7.98
9	LEND	ЛЭНДМН ББСБ	891379	51379749.33	62	50.21	-10.21
10	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	64314	45451517.01	708	699	-0.99
11	TUM	ТҮМЭН ШУВУУТ	204,761	35,206,346	180	160	-1.75
12	MFC	МОНОС ХҮНС	515982	34403987.93	70	64.02	-0.09
13	SUU	СҮҮ	116,082	22,778,013	206	185	-7.19
14	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	228,302	16,976,338	79	68	-11.34
15	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	30,513	16,010,184	540	500	4.14
16	ITLS	АЙТҮҮЛС	175,577	14,436,178	88	79	-9.34
17	AIC	АРД ДААТГАЛ	21,311	14,377,157	711	631	-4.23
18	MNP	МОНГОЛ ШУУДАН	21715	12189327.03	618	535	-4.86
19	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18,228	11,771,063	800	500	34.00
20	RMC	РЕМИКОН	357,979	9,540,993	28	26	-8.03



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.08.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-08-01	2019-08-31		
1	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18,228	500.00	670.00	170.00	34.00
2	ХҮРД	79	3,236.00	4,279.00	1,043.00	32.23
3	МОНГОЛ ШИЛТГЭЭН	27	297.50	350.00	52.50	17.65
4	БӨӨНИЙ ХУДАЛДАА	10	300.01	345.00	44.99	15.00
5	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	2	1,597.00	1,836.00	239.00	14.97
6	АРИГ ГАЛ	344	3,200.00	3,550.00	350.00	10.94
7	БАГАНУУР	2,794	1,000.00	1,100.00	100.00	10.00
8	БИ ДИ СЕК	68,251	833.00	899.51	66.51	7.98
9	МОГОЙН ГОЛ	108	8,000.00	8,620.00	620.00	7.75
10	УБ-БҮК	1	399.00	429.00	30.00	7.52
11	ГЕРМЕС ЦЕНТР	13,928	120.00	129.00	9.00	7.50
12	ТАЛХ ЧИХЭР	464	17,000.00	18,000.00	1,000.00	5.88
13	ИНВЕСКОР ББСБ	57,466	1,820.00	1,920.00	100.00	5.49
14	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	1,498	381.00	400.00	19.00	4.99
15	МОНГОЛ ШЕВРО	59	1,720.00	1,800.00	80.00	4.65
16	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	30,513	480.10	500.00	19.90	4.14
17	ХАЙ БИ ОЙЛ	33,356	50.00	52.00	2.00	4.00
18	МАХИМПЕКС	457	2,506.00	2,600.00	94.00	3.75
19	ЭРДЭНЭТ ХҮНС	5	2,900.00	3,000.00	100.00	3.45
20	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	203	27,000.00	27,900.00	900.00	3.33

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.08.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-08-01	2019-08-31		
1	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	1,861	195.00	120.00	-75.00	-38.46
2	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	336,815	1,911.00	1,294.00	-617.00	-32.29
3	ӨНДӨРХААН	10	2,660.00	1,923.00	-737.00	-27.71
4	ХАР ТАРВАГАТАЙ	20	8,925.00	7,000.00	-1,925.00	-21.57
5	МОНГОЛ САВХИ	35	650.00	553.00	-97.00	-14.92
6	НОЁТ ХАЙРХАН	3	425.00	363.00	-62.00	-14.59
7	БӨХӨГ	23	2,200.00	1,900.00	-300.00	-13.64
8	ХӨХ ГАН	3,784	80.00	70.00	-10.00	-12.50
9	АРД КРЕДИТ ББСБ	228,302	77.00	68.27	-8.73	-11.34
10	МЕРЕКС	73,075	27.00	24.00	-3.00	-11.11
11	ЛЭНДМН ББСБ	891,379	60.14	54.00	-6.14	-10.21
12	АВТО ИМПЕКС	111	1,890.00	1,700.00	-190.00	-10.05
13	ШАРЫН ГОЛ	375	1,551.00	1,400.00	-151.00	-9.74
14	АЙТҮҮЛС	175,577	87.55	79.37	-8.18	-9.34
15	АПУ	331,380	559.11	508.50	-50.61	-9.05



МХБ-ийн 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2019 оны эхний хагас жилд дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

- Хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна. Энэхүү арилжааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.5 тэрбум төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.
- Зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.83%-иар өсч, 2.6 их наяд төгрөгт хүрлээ.
- МХБ нь хагас жилийн хугацаанд хамгийн олон буюу 4 компанийн үнэт цаасыг шинээр бүртгэж, анхдагч зах зээлд нийт 42.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад даруй 3 дахин өссөн үзүүлэлт боллоо.
- Бүртгэлтэй компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, арилжаа нь зогссон 22 компанийг бүртгэлээс хасав.
- Мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлж, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах үүднээс "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг боловсруулан баталж, СЗХ-гоор батламжлуулахаар хүргүүлээ.
- Хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх үүднээс нийт 5 аймагт нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 7000 гаруй иргэдийг хамрууллаа.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй хэдий ч нийтдээ 994.4 сая төгрөгийн орлого олж, 716.9 сая төгрөгийн зардал гаргаснаар нийт 277.4 сая төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба МИТ цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт 482.1 сая төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайландаа татварын өмнөх байдлаар 204.6 сая төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 25.3%-аар, арилжааны шимтгэлийн орлого 34.6%-аар, хураамж үйлчилгээний хөлс 24.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Улсын төсөвт нийт 274.9 сая төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн нь өмнөх оны мөн үеэс 25.1%-аар өссөн үзүүлэлт болсон байна.

"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЖ, ХУВЬЦААНЫ АРИЛЖАА ЭХЭЛЛЭЭ

СЗХ-ны 2019 оны 5 сарын 8-ны өдрийн 102 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Жинст Увс" ХК (MSE:JIV)-д "Ард

Санхүүгийн Нэгдэл" хаалттай хувьцаат компанийг нэгтгэхийг зөвшөөрсний дагуу тус нэгдсэн компани болох "Ард Санхүүгийн нэгдэл" ХК-ийн үнэт цаас 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн AARD симболтойгоор арилжигдаж эхэллээ. Энэхүү үйл явдлыг тохиолдуулан СЗХ-ны дэд дарга Д.Баярсайхан, МХБ-ийн Захиргаа, Санхүүгийн газрын захирал Н.Дөл-Эрдэнэ, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн ТҮЗ-ийн дарга П.Батбаяр, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг болон бусад холбогдох албан тушаалтнууд арилжааны цан цохих ёслолын үйл ажиллагаанд оролцож, МХБ-ийн үнэт цаасны 6,031 дэхь удаагийн арилжааг эхлүүлээ.

"Ард санхүүгийн нэгдэл" ХК нь "Жинст Увс" ХК-тай ийнхүү нэгдсэнээр урвуу нэгдэл (reverse takeover) буюу хаалттай компани нээлттэй компанид нэгтгэгдэх үйл явц амжилттай хэрэгжиж, Монголын хөрөнгийн зах зээлд нэгэн шинэлэг үйл явдал боллоо.

Тус нэгдлийн бүрэлдэхүүнд "Ард Даатгал" ХК, "Ард Кредит ББСБ" ХК, "Ард Секюритиз УЦК" ХХК, "Ард Лайф" ХХК, "Ард Актив" ХХК, "Ард Менежмент" ХХК, "Ард Бит" ХХК, "Тэнгэр Систем" ХХК, "Монгол Шуудан" ХК, "ТөүПэй" ХХК, "Номын Хишиг" ХХК, "Крипто Үндэстэн" ХХК, "Дижитал Эксчэнж Монголиа" ХХК болон "ЭМИСи Партнерс" ХХК зэрэг компаниуд багтдаг бөгөөд өөрийн охин болон хараат компаниудаар дамжуулан Монголын хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцдог билээ. Тухайлбал, тус нэгдэл нь 2016 онд "Монгол шуудан" ХК-ийн хувьчлалыг амжилттай хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байсны зэрэгцээ "Ард даатгал" ХК болон "Ард кредит ББСБ" ХК нь МХБ-д үнэт цаасаа шинээр бүртгүүлж, олон нийтээс амжилттай хөрөнгө татан төвлөрүүлсэн билээ.

АРХАНГАЙ, ХӨВСГӨЛ АЙМАГТ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК, "Гүүдсек УЦК" ХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг" арга хэмжээг Архангай, Хөвсгөл аймгуудад 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 24-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүү, үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан, цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 2,000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.



“ТЕРМЕС ЦЕНТР” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Гермес Центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор компанийн 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар баталгаажсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5 төгрөг 70 мөнгө буюу нийт 447,695,105.7 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 9 сарын 02-ны өдрөөр тогтоож, 2019 оны 9-р сарын 12-ны өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан тараахаар шийдвэрлэсэн байна.

"БАЯЛАГ СҮМБЭР" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ГАРГАЛАА

Ванвату улсын иргэн Yeh Montgomer нь "Баялаг Сүмбэр" ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтын дагуу бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа.

Санал болгож буй үнэ: 3 /гурван/ төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 64,661 буюу 89.6 хувь

Худалдан авах тоо ширхэг: 7,496 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити центр 1003 тоот Дэлгэрэнгүй мэдээллийг 99087502 утсаар авна уу.

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР О.БОЛДБААТАР ТОМИЛОГДЛОО

"ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 8 сарын 15-ны өдрийн хурлын 19/40 шийдвэрээр О.Болдбаатарыг компанийн гүйцэтгэх захирлаар томилсныг Санхүүгийн зохицуулах хороо хянаж үзэн 2019 оны 8 сарын 23-ны өдрийн 7/3136 тоот албан бичгээр тус компанийн гүйцэтгэх захирал Булган овогтой Гантулгыг өөрчилж, шинээр томилогдож буй гүйцэтгэх захирал О. Болдбаатарыг "ЛэндМН ББСБ" ХК-ийн гүйцэтгэх захирлаар бүртгэсэн байна.

Шинээр томилогдсон гүйцэтгэх захирал О.Болдбаатарын мэргэжил, ажлын туршлагын талаарх дараах мэдээллийг "ЛэндМН ББСБ" ХК-аас ирүүлсэн байна:

Мэргэжил: Санхүүч, аудитор мэргэжилтэй, ОУ-ын Мэргэшсэн Нягтлан Бодогч

Ажлын туршлага:

- 2004–2005 онд Турк улсын "Denge Denetim/Mazars" компанид аудитор
- 2005–2006 онд "Далайван Аудит" ХХК-д Ахлах аудитор
- 2006–2009 онд "Эрнст энд Янг Монголиа" компанид

Үйл явдал

Ахлах аудитор

- 2010–2015 онуудад "PwC Монголиа" компанид Ахлах менежер
- 2015–2016 PwC компанийн Их Британи улс дахь салбарт менежер 2016–одоог хүртэл "АНД Глобал" компанийн үүсгэн байгуулагч, санхүү эрхэлсэн захирал, "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн дарга

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй "Монгол Базальт" ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

“Монгол Базальт” ХК нь үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлж цагт 1 тонн эрдэс хөвөн үйлдвэрлэдэг байсныг 1.5 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлснээр 2019 оны хагас жилийн байдлаар борлуулалтын орлого 1.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 478.7 сая төгрөг буюу 74.9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, энэ онд үйлдвэрлэлийн бүтээмжийг 2 дахин их буюу цагт 2 тонн эрдэс хөвөн үйлдвэрлэхээр үйлдвэрлэлийн шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд борлуулалтын орлогыг 4 тэрбум төгрөгт хүргэхээр ажиллаж байгаа тухай танилцууллаа.

“АПУ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн тайлангаа МХБ дээр олон нийтэд нээлттэй танилцуулах үйл ажиллагаанд АПУ ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр оролцлоо. Тайлант хугацаанд АПУ ХК болон түүний охин 9 компани нь нийт 2,031 ажилтантайгаар ажиллаж, нэгдсэн байдлаар дараах голлох үр дүнгүүдийг гаргасан байна. Үүнд:

- Бүтээгдэхүүний нэр төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11% хувиар нэмэгдэж, 308 нэр төрлийн 62,9 сая литр бүтээгдэхүүн борлуулсан;
- Цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9% хувиар өсч, 218 тэрбум төгрөгт хүрсэн;
- Тайлант үеийн байдлаар улсын төсөвт төлсөн татварын хэмжээ нийт 140 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 17% хувиар өссөн;
- 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 46 төгрөг буюу нийт 48.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн нь өнгөрсөн 10 жилийн түүхэн хугацаанд хамгийн өндөр ногдол ашиг зарласан үзүүлэлт боллоо;
- Хүү, татвар, элэгдэл хорогдлын зардлаас өмнөх ашгийн хэмжээ буюу EBITDA өмнөх оны мөн үетэй ижил түвшинд буюу 56 тэрбум төгрөг гарсан үзүүлэлттэй байна.



“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй танилцуулах үйл ажиллагаанд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг, Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо нар 2019 оны 8 сарын 8-ны өдөр оролцлоо.

Тайлант хугацаанд “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 7.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь тус компанийн хувьд хамгийн их ашигтай ажилласан үзүүлэлттэй хагас жил болсон байна. 2018 онд 6 компанид шинээр хөрөнгө оруулалт хийснээр тайлант хугацааны эцэст тус нэгдлийн хөрөнгө оруулалттай компанийн тоо 15-д хүрсэн байна.

- Нийт хөрөнгийн хэмжээ 73.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.6 тэрбум төгрөгөөр буюу 21 хувиар өсчээ. Энэхүү өсөлтөд “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO голлох нөлөөг үзүүлж, эзэмшлийн хувийн үнэлгээ нь 10 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Хөрөнгө оруулалтын орлого өссөнөөр хагас жилийн байдлаар 7.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.
- Ард Апп-ыг олон нийтэд танилцуулснаар тус аппликейшнийг хэрэглэгчдийн тоо 140 мянгад хүрсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг аппликейшнд бүрэн оруулахаар ажиллаж байна.

Хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах “Ард Менежмент” ХХК-ийн хүсэлтийг СЗХ-оос зөвшөөрсний дагуу энэ оны хоёрдугаар хагаст “Үндэсний Хувьчлалын Сан”-г үүсгэн байгуулж, олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү сан үүсгэн байгуулагдсанаар Монголд олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх анхны хөрөнгө оруулалтын сан болох юм.

“АРД КРЕДИТ ББСБ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн тайлангаа олон нийтэд нээлттэй танилцуулах үйл ажиллагаанд “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г. Сүхбаатар 2019 оны 8 сарын 8-ны өдөр оролцож тайлангаа танилцууллаа.

Тайлант хугацаанд “Ард Кредит ББСБ” ХК нь 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь тус компанийн хувьд хагас жилийн хугацаанд хамгийн их ашигтай ажилласан үзүүлэлт болсон байна. Тус компани нь 2019 оны эхний улиралд амжилттай IPO хийснээр хагас жилийн хугацаанд дараах үр дүнгүүдийг гаргажээ. Үүнд:

- Нийт хөрөнгө 18.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 8.2 тэрбум төгрөгөөр буюу 78 хувиар өссөн;
- Цэвэр зээлийн багц өмнөх оноос 5.2 тэр бум төгрөгөөр буюу 70 хувиар өсч 12.7 тэрбум төгрөгт хүрсэн;
- Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-аар дамжуулан нийт 13.7 тэрбум төгрөгийн зээлийг 33,000 гаруй харилцагчдад олгосон байна;

Үйл явдал

Япон улсын Крауд Кредит сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийт 5 сая долларын санхүүжилт авахаар тохиролцсоны дагуу тайлант хугацаанд гэрээний дагуу гурван удаагийн санхүүжилтийг авсан байна.

“АРД ДААТГАЛ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Ард Даатгал” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8 сарын 8-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Нийт хөрөнгө өмнөх оныхоос 8.5 тэрбум төгрөгөөр буюу 64 хувиар өсч, 21.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 5,8 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба цэвэр хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс даруй 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Хөрөнгө оруулалтын орлого 1.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 200 хувиар өссөн үзүүлэлт болсон байна.
- 2019 оны эхний хагас жилд 1.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 724 хувиар өссөн үзүүлэлт болжээ.

2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 25.27 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу нийт 1,711 хувьцаа эзэмшигчиддээ 631 сая төгрөгийн ногдол ашгийг амжилттай хуваарилсан байна.

“ТҮМЭН ШУВУУТ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 2-р ангилалд бүртгэлтэй “Түмэн шувуут” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8 сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд дараах үр дүнд хүрчээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 31.5 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оны эхний хагас жилийн үзүүлэлтээс 6.8 сая ширхгээр буюу 27.5%-иар өссөн байна.
- Санхүүгийн үзүүлэлтийг харвал эхний хагас жилд 10.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2.1 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 10.3 төгрөгийн ногдох ашигтай ажилласан байна. Харин тус үзүүлэлтийг 2018 оны мөн үетэй харьцуулбал, борлуулалтын орлого 2.0 тэрбум төгрөг буюу 26%-иар, цэвэр ашиг 0.87 тэрбум төгрөг буюу 66%-иар тус тус өсчээ.
- Борлуулалтаа нэмэгдүүлэх ажлын хүрээнд харилцагчдын тоог 200-гаар нэмэгдүүлж ажилласан байна.

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн тухайд: -“Тахианы аж ахуй”-н өргөтгөл, шувууны 3 байр барих ажил 50%-ийн /Барилга, тоног төхөөрөмж байрлуулах ажил явагдаж байна./ гүйцэтгэлтэй байна. -“Усалгаатай газар тариалан”-ийн ажлын хүрээнд хийгдсэн бороожуулагч угсрах ажил 100%-ийн гүйцэтгэлтэй. - Сангасны органик бордооны үйлдвэрийн ажил 50%-ийн /9-р сард ашиглалтанд оруулахаар ажиллаж байна/ гүйцэтгэлтэй байна.



“ТАЛХ ЧИХЭР” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Талх чихэр” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр танилцууллаа. Тайлант хугацаанд:

- “Талх чихэр” ХК 25.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 751.1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Борлуулалтын орлого 2018 оны мөн үеэс 5.2 тэрбум төгрөгөөр өсч, ашигт ажиллагааны түвшин 0.75 болж өмнөх оны мөн үеэс 0.01 пунктээр өссөн байна.
- Олон улсын хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000:2005 стандартын гэрчилгээг баталгаажуулах шалгалтад орж, уг стандартыг амжилттай хэрэгжүүлж байгаагаа баталгаажуулжээ.
- ТОП-100 аж ахуйн нэгжид сүүлийн жилүүдэд тасралтгүй багтаж, Нийслэлийн шилдэг татвар төлөгч байгууллагаар шалгарсан байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд “Ухаалаг хэрэглэгч” хөтөлбөрийг амжилттай явуулсан байна.
- 105 харилцагчтай түншийн гэрээ шинээр байгуулан ажилласны зэрэгцээ 3000 харилцагчдыг нэгтгэсэн арга хэмжээг зохион байгуулсан.

“Та Чи” бэйкери Хотол үйлдвэр, “Та Чи” Март 5-р салбарыг нээн ажиллуулж байна.

“Талх Чихэр” ХК энэ ондоо багтаан харилцагч хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүнүүдийн нэр төрлийг нэмэгдүүлэхээс гадна үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг шат дараалалтайгаар хийж байгаа тухай танилцууллаа.

“ГОВЬ” ХК ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Говь” ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- 2019 оны эхний хагас жилд “Говь” ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар өсч 68.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Хонконг болон АНУ-ын Сан Франциско хотод франчайз дэлгүүрээ нээж, гадаад зах зээлээ тэлэв.
- Хамгийн анхны 100% ноолууран нимгэн даавуун хослолыг худалдаанд гаргасан байна.
- 26 жилийн түүхтэй “Гоёо” ХХК-г худалдан авсантай холбогдуулан уг 2 компанийн нэгдэлтэй холбоотой ажил явагдаж байна.

“Говь” ХК нь цаашид энэ онд багтаан дэлхийн 2 дахь том зах зээл болох АНУ-д үйл ажиллагаагаа тэлж, Лос Анжелес хотод зөвхөн онлайнгаар борлуулалт хийх зорилготой өөрийн салбар компанийг нээхээр ажиллаж байгаагийн зэрэгцээ Тува, Чиндао, Киев хотуудад

франчайз дэлгүүр нээж ажиллахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

“СҮҮ” ХК САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА НЭЭЛТТЭЙ ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 8-р сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. 2019 оны эхний хагас жилд “Сүү” ХК үйл ажиллагаагаа сайжруулах, шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, үйлдвэрийн их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тайлант хугацаанд хүрсэн үр дүнг 2018 оны эхний хагас жилийн мөн үетэй харьцуулан танилцуулахад:

- Бэлтгэн нийлүүлэгчдээс 8.35 сая литр буюу 9.1 тэрбум төгрөгийн түүхий эд татан авч сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь сүү бэлтгэлийн биет дүн 4%, мөнгөн дүн 3%-иар тус тус өссөн үзүүлэлт болсон байна.
- Борлуулалтын биет дүн 14.8 мянган тонн бүтээгдэхүүнд хүрч 8% өссөн, цэвэр борлуулалт 36,5 тэрбум төгрөгт хүрч, 5% өссөн бөгөөд цэвэр ашиг 71%-иар өсч 4.19 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 2019 оны эхний хагас жилийн томоохон хөрөнгө оруулалтыг танилцуулбал: РЕТ савлагааны шугамд 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 100% хийж гүйцэтгэсэнээс гадна парк шинэчлэлийн хүрээнд борлуулалтын 3, сүү бэлтгэлийн 7 автомашинд нийт 920 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Түүнчлэн, ERP буюу байгууллагын нөөц төлөвлөлтийн систем нэвтрүүлэх ажлын хүрээнд 88 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. РЕТ шугамаар орчин үеийн хэрэглэгчдийн амьдралын хэв маягт тохиромжтой, авч явахад авсаархан, 290гр болон 870гр-ын савлагаа бүхий цөцгийтэй, хад, гүзээлзгэнэ жимстэй “Амтлаг” брэндийн тараг үйлдвэрлэн, зах зээлд амжилттай нэвтрүүлээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь хэмжээ 48% хэвээр байна.
- ЕСБХБ болон бусад зөвлөх компаниудтай хамтран компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Ирэх улирлуудад сүү хүлээн авах, боловсруулах цехийн төслийг хэрэгжүүлэх, агуулах, авто гаражийн барилгын шинэчлэл, борлуулалтын нэг цэгт хүрэх давтамжийг нэмэгдүүлэх, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргахаар ажиллаж байгаа тухай танилцууллаа.



“ИНВЕСКОР ББСБ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 3-р ангилалд бүртгэлтэй "Инвекор ББСБ" ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8 сарын 13-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд дараах үр дүнд хүрчээ. Үүнд:

- Харилцагчийн тоо өмнөх оны мөн үеэс 170 хувиар өсч 4,712, зээлийн багц 103 хувиар өсч 52.9 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 35 тэрбум төгрөгөөр буюу 117 хувиар өсч, 65.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Нийт өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24 тэрбум төгрөгөөр өсч 35.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

8.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн ба нийт орлого өмнөх оны мөн үеэс даруй 68 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны эхний хагас жилд 4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 56 хувиар өссөн үзүүлэлт болжээ.

"МАНДАЛ ДААТГАЛ" ХК 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй Мандал Даатгал ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 сарын 14-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- 2019 оны эхний хагас жилд "Мандал Даатгал" ХК-ийн хураамжийн орлого 18.2 тэрбум төгрөгт хүрч зах зээлийн 18 хувийг эзэлж байна.
- Цэвэр ашиг 3.4 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарт тэргүүлэх үзүүлэлт бөгөөд үнэт цаасны танилцуулгад 2019 оны жилийн эцсээр олохоор төлөвлөсөн цэвэр ашгийн хэмжээг 100 хувь биелүүлсэн байна.
- Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал болон барилга угсралтын даатгалын хураамжийн орлогоор тэргүүлж байна.

"Мандал Даатгал" ХК-ийн нийт хөрөнгө 42.6 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын даатгалын зах зээлд хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байна. Мөнгөн хөрөнгө оруулалтын хэмжээ 27.3 тэрбум төгрөгт хүрснээс Монголын хөрөнгийн зах зээлд 7.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт хийжээ

"ДАРХАН НЭХИЙ" ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Дархан Нэхий" ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 сарын 15-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Дэвсгэрийн зориулалттай үстэй боловсруулсан арьсны шугам нэмж суурилуулснаар бүтээгдэхүүний чанар сайжирснаас гадна 4000 арьс нэмж боловсруулах хүчин чадалтай болжээ.
- Хромын агууламжгүй, эко 100 мянган ширхэг арьсыг Европын зах зээлд экспортлох захиалга авсан байна.
- Ноос угаах автомат үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ашиглалтанд оруулсан байна.

- Тус компанийн охин компаниудын үйл ажиллагааны тухайд "Гранд Як" ХХК нь Дархан хотын төвд 12 давхар, 108 өрөө бүхий 3 одтой зочид буудлыг 2019 оны 11 сард албан ёсоор ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Нэхий боловсруулах үйл ажиллагаа явуулдаг охин компани болох "Нэхий Таннери" ХХК нь шахмал ширний үйлдвэрийг арьс ширний салбарт анхлан нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд хатуу хог хаягдлыг дахин ашиглаж, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар байгальд ээлтэй хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэхээр зорьж байна. Худалдааны үйл ажиллагаа эрхлэх охин компани болох "Нэхий Трейд" ХХК нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт өөрийн нэрийн барааны шинэ салбар дэлгүүр нээхээр төлөвлөж байна.

- "Дархан Нэхий" ХК-ийн хэмжээнд цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 хувиар буурч, 8.4 тэрбум төгрөгт хүрсэн 4 компанийн зүгээс оны эцэс гэхэд борлуулалтын орлогыг өмнөх оноос 37 хувиар өсгөх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд энэхүү зорилтын хүрээнд үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөжүүлж, шахмал ширний шугамыг суурилуулах, шир боловсруулах явцад хаягдал болдог хуулдас, захалгааны хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг энэ онд багтаан ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

- 2014 оны 8-р сарын 15-нд эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 60 сарын хугацаатай төслийн зээлд хамрагдсан бөгөөд уг зээлийг хугацаандаа буюу 2019 оны 08-р сарын 15-нд амжилттай төлж дууссан байна.

Туршилтийн технологийн цехийн их засварыг хэрэгжүүлж, шинэчлэл хийн, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргахаар ажиллаж байгаа тухай танилцууллаа.



"МОНГОЛ ШУУДАН" ХК 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй "Монгол шуудан" ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 сарын 15-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

Тайлант хугацаанд тус компани нь шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажилласан бөгөөд дараах голлох үр дүнд хүрчээ. Үүнд:

- Улс хоорондын шуудангийн үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд дуудлагын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, процессийг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний зэрэгцээ улс хоорондын шуудангийн ялган боловсруулах төвийн барилгын ажлыг эхлүүлжээ.
- Дотоодын шуудан хүргэлтийн үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд дотоод шуудан ялган боловсруулах төвийг байгуулж, Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн төвийг алслагдсан 11 сумдад нээжээ.
- Логистик үйлчилгээг өргөжүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар болон хот хоорондын логистик үйлчилгээний төвийг шинээр байгуулж, хот хооронд өөрийн тээврээр шуудан, ачаа тээвэрлэх үйлчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.
- Санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр даатгалын үйлчилгээний орлогын хэмжээг 15%-аас 25% болгон нэмэгдүүлэв.
- 2019 оны эхний хагас жилд 7.5 тэрбум төгрөгийн орлоготой, 307.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2019 онд 468 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан нь өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 27.4 хувиар өссөн үзүүлэлт болсон байна.

Хувьцааны хаалтын ханш 691.16 төгрөг, зах зээлийн үнэлгээ 68.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 19.52 хувиар, арилжаалагдсан хувьцааны тоо ширхэг 40.35 хувиар тус тус өссөн байна.

"МИК ХОЛДИНГ" ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "МИК Холдинг" ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа МХБ дээр 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- Нийт хөрөнгийн хэмжээ 4 их наяд төгрөг хүрч, 32.5 тэрбум төгрөгийн цэвэр хүүгийн орлого, 27.0 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар татварын дараах

цэвэр ашгийг 5.5 тэрбум төгрөгт хүргэж ажилласан байна.

- 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдөр тус компани нь 3 жилийн хугацаатай, жилийн 9.75 хувийн хүүтэй 144 A/Reg S төрлийн 300.0 сая ам.долларын үнийн дүн бүхий "Өэлүн" (SGX:MGMGTGE) бондыг Сингапурын хөрөнгийн биржээр дамжуулан олон улсын хөрөнгийн зах зээл дээр 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдөр амжилттай арилжаалсан. "Өүлэн" бондыг амжилттай арилжаалснаар "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК нь Монгол Улсаас олон улсын зах зээл дээр үнэт цаас арилжаалсан хувийн хэвшлийн 3 дахь байгууллага болсон юм.

Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ нийт хөрөнгийн 5.3%, нийт зээлийн хөрөнгийн хэмжээ 79.4%, шинээр гаргасан "Өэлүн" бондын хэмжээ 19.9%-ийг тус тус бүрдүүлж байна.

"ЛЭНДМН ББСБ" ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "ЛэндМН ББСБ" ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа МХБ дээр 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд тус компани нь цахим зээлийн болон төлбөр тооцооны үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласан бөгөөд дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- LendMn open platform-ийг олон нийтэд танилцуулж, онлайн дэлгүүр, хямдралын купон, олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, хандивын системийг аппликейшндээ шинээр нэвтрүүлжээ.
- Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэрээт харилцагчийн тоо 2.5 дахин, олгосон зээлийн тоо 4.6 дахин, олгосон зээлийн дүн 5 дахин тус тус өсчээ.
- Цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2 дахин өсч, 2.56 тэрбум төгрөгт хүрчээ.

Хувьцааны арилжааны хувьд өдөрт дунджаар 12.6 сая төгрөгийн хувьцаа МХБ-ээр дамжин арилжигдсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 8.48%-тай тэнцэж байна.

Цаашид тус компани нь БНСУ-ын зах зээлд хадгаламжийн бичиг гаргах замаар хувьцаагаа арилжихаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.



“ТАВАН ТОЛГОЙ” ХК 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "Таван толгой" ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- 1.1 сая тонн нүүрс олборлон борлуулж, 123.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 19 хувиар өсч, 23 тэрбум төгрөгт хүрчээ.
- Нүүрс борлуулалтын бүтцийн хувьд 53 хувь нь коксжих нүүрс, 23 хувь нь сул коксжих, 7 хувь нь коксжих чанаргүй нүүрс, үлдсэн хувь нь дотоод зах зээлд борлуулсан нүүрс тус тус эзэлж байна. Борлуулалтын орлого нэмэгдэж цэвэр ашиг өсөхийн зэрэгцээ уурхайн уур геологийн нөхцөл байдлаас шалтгаалан олборлолтын өртөг өссөн байдалтай байна.

Улс, орон нутгийн төсөвт 38.9 тэрбум төгрөгийг эхний хагас жилийн байдлаар бүрдүүлсэн.

"ЖИНСТ УВС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Жинст Увс” ХК нь 2018 оны 4 сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-г нэгтгэх замаар компаниа өөрчлөн зохион байгуулах, өөрчлөн зохион байгуулагдсан компанийн оноосон нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн билээ. Энэхүү өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагааг Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрч (2019 оны 5 сарны 8-ны өдөр зөвшөөрч, 102 тоот тогтоол, 2019 оны 6 сарын 20-ны өдөр 428 тоот шийдвэр), 2019 оны 7 сарын 18-ны өдөр холбогдох өөрчлөлтүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгэсэн. Иймд “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг “Жинст Увс” ХК шилжүүлэн авсан, “Жинст Увс” ХК нь оноосон нэрээ өөрчилж “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болсныг тус тус мэдэгдэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN